



ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 8/НЗ

Бэрх хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, Захирагчийн Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн №05 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гал түймэр унтраах аврах 42 дугаар ангийн 528м² газрыг нөхөн олгох, зориулалтын зам засварлах, хашааг сунгахад 3.000.000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 3.000.000 (Гурван сая) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас холбогдох хууль, дүрэм журмын дагуу гарган зарцуулахыг Захирагчийн ажлын албаны нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232501047



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР**

Чингис хот, Харлан сум, Хэнтий аймаг, 23119

Утас/факс: (976) 7056 3024

Цахим хуудас: henti@nema.gov.mn

Цахим шуудан: www.nema.khe.gov.mn

**БАТНОРОВ СУМЫН БЭРХ ТОСГОНЫ
ЗАХИРАГЧ Ч.ЭНХЖАВХЛАН ТАНАА**

2025.09.11 № 48/309
танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

2024 онд Бэрх тосгонд шинээр хатуу хучилттай авто зам тавих үед тус газрын Гал түймэр унтраах, аврах 42 дугаар ангийн өдөр тутмын дасгал сургуулилтын талбайтай огтлолцож тухайн замыг үргэлжлүүлэн барих боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Тухайн үед орон нутгийн холбогдох албан тушаалтнуудын шийдвэрээр ангийн зүүн талын 48 метр урттай бетон суурьтай төмөр хашааг нураан, газрын хэмжээнээс 528м2 талбайг хасаж, дараа нь дээрх газрыг нөхөн олгох, хашааг засварлах нөхцөлтэйгөөр авто замын ажлыг үргэлжлүүлсэн боловч одоог хүртэл энэхүү ажил хийгдээгүйн улмаас алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт дадлагыг хийж чадахгүй, албаны бэлтгэл бэлэн байдал алдагдах. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 180 дугаар зарлигаар батлагдсан "Цэргийн дотоод албаны дүрэм", "Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага MNS 6412" стандарт зөрчигдөхөд хүрч байна.

Иймд гал унтраах ангийн талбайн хэмжээнээс хасагдсан газрыг нөхөн олгох, зориулалтын зам засварлах, хашааг сунгаж барих ажлыг 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хийж дуусгана уу.

Хэрэв энэхүү хугацаанд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд, тус байгууллагаас эрх бүхий байгууллагуудад хандаж, хууль тогтоомжийн хүрээнд дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг анхааруулж байна.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЭРДЭНЭБАТ



837503020